ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1.Байршил Монгол Улс Улаанбаатар хот Энхтайваны өргөн чөлөө-49 "Улсын Нэгдүгээр Төв Эмнэлэг" А блокын 3-р давхарын Урологи Андрологийнтасгийн засварын ажил

2.Ажлын цар хэмжээ, ажлын даалгавраас ажлын тоо хэмжээг авч ажлуудыг хийж гүйцэтгэнэ.

3.Засварын ажлын зохион байгуулалт, түүнд тавигдах шаардлагууд

3.1.Ажлыг гүйцэтгэж байх явцад технологийн үе шат бүрт гүйцэтгэсэн ажлыг төслийн менежерт үзүүлж, танилцуулж байна.

3.2.Ажил гүйцэтгэх явцад талбайд ажил гүйцэтгэж буй нийт ажилчидад хөдөлмөр аюулгүй ажиллагааны зааварчилгаа тогтмол өгч ажиллана.

3.3.Гэрээнд тусгагдсан бүх ажлыг Монгол улсад мөрдөгдөж буй хууль тогтоомж, БНбД, стандартын дагуу хийж гүйцэтгэнэ.

3.4.Засварын ажлыг хийж гүйцэтгэхдээ гэрээний тусгай нөхцөлд заасны дагуу хугацаанд нь ашиглалтанд хүлээлгэж өгөхөөр ажлын талбайн зохион байгуулалтыг хийх шаардлагатай.

3.5.Техникийн тодорхойлолтод өгөгдсөн материалын загвар өөрчилөгдөх тохиолдолд захиалагчын төлөөлтэй заавал зөвшилцөнө.

3.6.Барилга засварын интерьер дизайн нь барилгын хийцлэлээс шалтгаалж өөрчилөгдөх зайлшгүй нөхцөлд үндсэн загварын зургыг өөрчилөлт хийлгүйгээр захиалгч талтай тохиролцож хийж гүйцэтгэнэ.

- ТААЗ:Одоо байгаа 60*60 хэмжээтэй угсармал таазыг бүрэн буулгаж таазны хэсгийн хуурсан хэсэг суларсан шавар зэргийг буулгана.Шинээр хийгдэх тааз нь төмөр рамтай гипсэн өнгөлгөөтэй тааз хийгдэх бөгөөд төмөр рамыг хоорондын алхам нь 40 сантиметрээс ихгүй зайгаар зангидаж, үндсэн тааз руу бэхэлгээг 1,2 метрээс ихгүй зайгаар бэхэлж өгнө.Гипсэн хавтан өнгөлгөөг замаскадаж, сайн чанарын усан суурьтай будагаар 2 үе будна.Заслын ажлыг гүйцэтгэхдээ Заслын ажлын БНбД гүйцэтгэх бөгөөд гүйцэтгэл ажилбарыг онцгой анхаарч нямбай хийнэ.
- ХАНА:Нийт гадаргуун хөндийрсөн шавар суларсан хэсгийг бүрэн буулгана.Коридорын ханын хийцлэл нь хулсан суурьтай эмнэлэгийн зориулалтай хавтан байх бөгөөд гол хэсгээр цэвэр модон ханын бариул байна.Дотор хэвтэн эмчилүүлэх хэсгийн өрөөний хана нь МДП суурьтай хуулган хана байх бөгөөд орны хэсгээр хатжуулсан өнгийн шилэн хийцлэлтэй байна.Өрөө болгонд байх ариун цэврийн өрөөнд сайн чанарын чулуун плита байна.
- ДОТОР ЗАСАЛ: Заслын ажлыг хийж гүйцэтгэхдээ таазанд усан суурьтай эмульсэн будаг, хананд усан суурьтай үнэргүй будаг байна.

- ШАЛ:Шаланд нийт гадаргууд 5мм-с 1см-н цементэн тэгшилгээ хийж, стандартын дагуу зүлгүүр хөрсжүүлэгч зэргийг хийж Gerflor брэндийн Ambiance загварын хулдаас наана.Ариун цэврийн өрөөнд сайн чанарын чулуун плита наах
- ГЭРЭЛТҮҮЛЭГ:Гэрэлтүүлэгийг цахилгаанд хэмнэлттэй led далд угсрадаг гэрэлтүүлэг байх бөгөөд гэрэлтүүлэгийн тэжээл холболтыг сольж асах зориулалтаар 2 утасны тусдаа тэжээлтэй зарчимаар явуулна. Гэрэлтүүлэгийн цахилгааны хуучин монтажыг бүрэн тэжээлээс салгаж 3эс голтой ПВ3 1*2.5мм-н орос утсаар хамгаалалтын хоолойд сүвлэж явуулна.Тухайн давхарт байх гэрэлтүүлгийн самбарыг бүрэн шинэчилнэ.
- ХҮЧИТ ТӨХӨӨРӨМЖ: Давхарын хүчит төхөөрөмж буюу хэрэглээний цахилгаан нь ПВ3 1*2,5мм-н орос утас байх бөгөөд цахилгааны тэжээл нь далд угсрана.Давхарын хүчит төхөөрөмжийн самбарыг бүрэн шинэчилнэ.
- СҮЛЖЭЭ: Дотоод сүлжээний системийг угсрахдаа CAT6 утас хэрэглэх бөгөөд хүлээн авагч төхөөрөмж нь Микротик Брэндтэй дүйцэхүйц бараа бүтээгдэхүүн байна.Сүлжээний разетька Schneider брэнд болон дүйцэхүйц тоноглол байна.
- ЦЭВЭР БОХИРЫН ШУГАМ: Шинээр гаргах ариун цэврийн өрөөнд цэвэр бохирын шугам сүлжээг 100% гүйцэтгэх бөгөөд БНбД40-06-16-г баримталж ажиллана.
- Шилэн хийцлэл: Засварын ажилд шилэн хийцлэл хийсэн тохиолдолд хатаалгын зориулалтын шилээр 100% хийж гүйцэтгэнэ.
- БУСАД:Барилга засварын явцад дотоод сүлжээ болон сантехникийн шугам хоолой, эмнэлэгийн тусгай хэрэглэл далдлахгүйгээр нэлхий таг тус бүрт гаргаж тэмдэглэгээтэй хийж гүйцэтгэнэ.Ажлын явцад ойлгомжгүй болон зөрчилдөх, барилгын хийцэд нөлөөлэхүйц асуудал үүсвэл захиалагч байгууллагад мэдэгдэж байна.

Улсын нэгдүгээр төв эмнэлгийн а блокын 3 дугаар давхарын Урологи, Андрологийн тасгийн ажлын даалгавар тоо хэмжээ

№	Хийгдсэн ажил	хэмжих нэгж	Тоо хэмжээ
	Буулгалтын ажил		
1	Хуучин модон хаалга буулгах	м2	44.28
2	Хуучин гэрэлтүүлэг буулгах	ш	28
3	Хуучин шалны хулдаас хуулах	м2	845.6
4	Хуучин модон цонх буулгах	м2	43.92
5	Хуучин хана шалны плита буулгах	м2	105.7
6	Хуучин цонхны тавцан буулгах	м2	19.03
7	разетька унтраалга буулгах	ш	65
8	Цахилгааны самбар буулгах	ком	1
9	Хана таазны будаг 100% хусаж цэвэрлэх	м2	1010.6

10	Халаалтын радиоторын хаалт буулгах	ш	42
11	Угаалтуур буулгах	ш	15
12	Холигч буулгах	ш	15
13	Тагтны хуучин модон хаалга буулгах	м2	51.66
	Заслын ажил		
1	Сүлжээний сувагчилал хананд ухах	м	1800
2	Сүлжээний тэжээл хар хоолойнд сүвэлж татах	м	1800
3	Сүлжээний холболтын үүр далд угсрах	ш	32
4	Сүлжээний тэжээл хайрцаг угсрах	ш	2
5	Сүлжээний разетька угсрах	м	32
6	Давхарын хүчит төхөөрөмжийн самбар угсрах	ком	2
7	Цахилгааны тэжээл хар хоолойнд сүвэлж татах татах	м	6500
8	Цахилгааны холболт үүр далд суулгах	ш	68
9	Разетька угсрах	ш	84
10	Унтраалга угсрах	ш	21
11	Ханын гэрэлтүүлэг угсрах	ш	38
12	Таазанд LED гэрэлтүүлэг угсрах	ш	216
13	Халаалтын радиоторын хуваарилах хаалт угсрах	ш	42
14	Угаалтуур угсрах	ш	15
15	Холигч угсрах	ш	15
16	510мм тоосгон өрлөг өрөх	м3	5.9
17	Ханын шавардлага хийх	м2	23.04
18	Вакуум цонх угсрах	м2	43.92
19	Цонхны чулуун тавцан угсрах	м2	19.03
20	Төмөр рамтай гипсэн тааз угсрах	м2	862.6
21	Хана таазанд замаска хийх	м2	1542.8
22	Таазанд усан суурьтай эмльсэн будгаар 2 үе будах	м2	862.6
23	Хананд тосон суурьтай будаг 3 үе будах	м2	680.2
24	Хананд хулсан хавтан өнгөлгөө хийх	м2	330.4
25	Хананд эмнэлгийн зориулалттай хулдаас босгож наах	м2	161.7
26	Төмөр булан наах	м	120
27	Хуванцар булан наах	м	74
28	Дотор модон хаалга угсрах /2050*1250мм/	м2	44.28
29	Халаалтын радиатор тосон будгаар будах	м2	21.35

30	Ханын вааран хавтан наах	м2	81.2
31	Шалны вааран хавтан наах	м2	24.5
32	Металл вакуум хаалга угсрах	м2	14.4
33	Шаланд хөрсжүүлэлт хийх	м2	862.6
34	Шаланд цементэн зуурмагаар тэгшилгээ хийх	м2	862.6
35	Шаланд эмнэлгийн зориулалттай хулдаас наах	м2	862.6